

ИРГЭДЭЭС 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ


2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Иргэдээс цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар


Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын удирдах албан тушаалтанд 2026 оны 1 дүгээр улиралд иргэдээс 4461 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1092 нэгжээр буюу 24,5 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 245 буюу 5.5 хувь нь санал, 4035 буюу 90.5 хувь нь өргөдөл, 181 буюу 4.0 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 290 буюу 6.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 51 буюу 1.1 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1136 буюу 25.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 961 буюу 21.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 161 буюу 3.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1860 буюу 41.7 хувь нь бусад / Хувийн хэргээс баримт бичиг, дипломын хавсралт авах, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой/ өргөдөл, гомдол байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 5267 буюу 93.6 хувийг шийдвэрлэж, 286 буюу 6.4 хувь нь ажиллагаанд байна.



Хоёр. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн талаар

2026 оны 1 дүгээр улиралд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 1303 санал, өргөдөл, гомдол, талархал, ирүүлсний 73 буюу 5.6 хувь нь санал, 1094 буюу 84.0 хувь нь гомдол, 126 буюу 9.7 хувь өргөдөл, 201 буюу 15.4 хувь нь талархал байна.


Нийт санал хүсэлт, өргөдөл, гомдол, талархлын 90 буюу 6.9 хувь нь цагдаагийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн, 312 буюу 23.9 хувь нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, 163 буюу 12.5 хувь нь зөрчлийн шинжтэй, 62 буюу 4.8 хувь нь мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой, 229 буюу 17.6 хувь нь тээврийн хэрэгслийн торгуультай холбоотой, 638 буюу 49.0 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэлийн 1077 буюу 82.7 хувийг шийдвэрлэж, 226 буюу 17.3 хувийг холбогдох алба, нэгжид судалж байна.

Гурав. Иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн нийт 552 өргөдөл, гомдолд 641 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 562 буюу 87.6 хувийг офицер, 79 буюу 12.4 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 38 буюу 7 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөө зөрчсөн, 149 буюу 27 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 89 буюу 16.1 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 9 буюу 1.6 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 5 буюу 0.9 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 50 буюу 9 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 8 буюу 1.4 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 60 буюу 11 хувь нь ажлын хариуцлага алдсан, 5 буюу 0.9 хувь нь архидан согтуурсан, 3 буюу 0.5 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 92 буюу 16.7 хувь нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль,

тогтоомж зөрчсөн, 3 буюу 0.5 хувь нь цалин тэтгэвэр, тэтгэмж буруу бодсон, 41 буюу 7.4 хувь нь бусад өргөдөл, гомдол тус тус эзэлж байна.

Нийт хүлээн авсан **552** өргөдөл, гомдлоос **461 буюу 83.5** хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, **91 буюу 16.5** хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл: Нийт өргөдөл, гомдлын 14 буюу 2.1 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад болон харьяаллын дагуу шилжүүлж, 54 буюу 8.5 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 9 буюу 1.5 хувь нь нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн, 22 буюу 3.5 хувийг бусад байдлаар шийдвэрлэж, 398 буюу 62 хувьд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй үндэслэлээр хааж шийдвэрлэн, 91 өргөдөл, гомдолд холбогдох 144 алба хаагч буюу 22.4 хувь нь ажиллагаанд байна.

ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС